

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Мягмар гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-17

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 18-41

---

*1.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг* 18-41

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 51 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор.

**Нэг.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав, баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг, Бордоо, ургамал хамгаалал, хөдөө аж ахуйн зохистой дадлын асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Отгонбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол ногоо төслийн эрх зүйн орчин төслийн менежер Б.Алтанцэцэг, “Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний нэгдэл” ТББ-ын тэргүүн, судлаач Г.Алтанхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

*Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулав.*

Төслийн 3-10, 12, 14, 16, 17 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний, сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг;

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний, сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг;

Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн тавьсан асуултад хууль санаачлагч, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний, сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг;

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний, сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг нар тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг үг хэлэв.

**Ж.Батжаргал:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Ц.Идэрбат, Ц.Цэрэнпунцаг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “дэмжлэг үзүүлэх” гэсний өмнө “төрөөс” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Органик” гэсний дараах “хүнсний” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль нь хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгацыг үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа шилжилтийн үеийн органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд хамаарна.

3.3.Амьтны тухай хуулийн 4.1.7-д заасан агнуурын амьтны түүхий эдээр органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“органик үйлдвэрлэл” гэж шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд нөөцийг зохистой ашиглах, экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалахад чиглэсэн уламжлалт арга барил, биологи ба механик арга технологийг хослуулан эрхлэхийг;

4.1.2.“органик бүтээгдэхүүн” гэж зохиомол аргаар нийлэгжүүлсэн нэмэлт бодис, эрдэс бордоо, пестицид, антибиотик, өсөлтийн даавар, хувиргасан амьд организм, цацраг туяа хэрэглээгүй энэ хуулийн 4.1.1-д заасан үйлдвэрлэлийн үр дүнг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7, 4.1.8, 4.1.9 дэх заалт нэмэх:

“4.1.7.“органик болохыг илэрхийлсэн тэмдэг” гэж эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн органик болон шилжилтийн үеийн түүхий эд, бүтээгдэхүүнийг гэрчилж, шошгод байршуулсан тэмдгийг;

4.1.8.“урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэж органик бүтээгдэхүүн нь органик бус бүтээгдэхүүнтэй холилдох, энэ хуулийн 8.2-т заасан органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн бодисын жагсаалтад зааснаас өөр бодисоор бохирдох эрсдэлээс зайлсхийхийг;

4.1.9."шошго" гэж органик бүтээгдэхүүний оноосон болон худалдааны нэр, органик үйлдвэрлэлийн талаар бичсэн, хэвлэсэн, зурсан, товойлгосон, сийлсэн аливаа үг, бичиглэл, мэдэгдэл, тэмдэг, дардас, зураг, тухайн бүтээгдэхүүнийг дагалдах баримт бичиг, хуудас, зүүлт, хавчуурга, дардас, бөгж, хүзүүвчийг." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

### **“5 дугаар зүйл. Органик үйлдвэрлэлд баримтлах зарчим**

5.1.Органик үйлдвэрлэлд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүн амын одоо ба ирээдүйд эрүүл, аюулгүй оршин тогтнох, тэдгээрийн дархлаа, дасан зохицох чадварыг дэмжих, нөхөн сэргээх;

5.1.2.экоосистемийн тэнцвэрийг хадгалах, биологийн олон янз байдлыг дэмжих, уламжлалт соёл, ёс заншлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нөөцийн тогтвортой байдлыг хангах;

5.1.3.зах зээлийн өрсөлдөөн, үйлдвэрлэлийн бүх үе шатанд шударга, энэрэнгүй ёсыг баримтлах, гадаад орцын хэрэглээг хязгаарлах, мэдлэгээ хуваалцах;

5.1.4.бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалах, нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн арга технологиор үйлдвэрлэл эрхлэх;

5.1.5.уламжлалт мэдлэгийг шинжлэх ухааны ололттой хослуулан органик үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэхдээ урьдчилсан үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, ил тод, нээлттэй шийдвэр гаргах;

5.1.6.шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийг сайн дурын үндсэн дээр эрхлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн **ХОЁРДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ЭРХЛЭГЧИЙН”** гэснийг **“ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА”** гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

### **“6 дугаар зүйл. Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага**

6.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь дараах нийтлэг шаардлагыг хангана:

6.1.1.энэ хуульд заасан шаардлага, журмыг баримталж органик үйлдвэрлэлд шилжих;

6.1.2.органик үйлдвэрлэлд шилжихдээ энэ хуулийн 8.2-т зааснаас бусад бодисыг тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэхээ зогсоох;

6.1.3.усны бохирдлоос сэргийлэх, цас, борооны усыг ашиглах, хаягдал багатай, эсхүл хаягдалгүй усны технологи ашиглах;

6.1.4.биотехникийн болон биологийн олон янз байдлын чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.1.5.өөрийн болон хөрш зэргэлдээ, нийтийн эзэмшлийн газрын байгаль орчин, эд зүйлсийг хамгаалах.

6.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь органик үйлдвэрлэлд шилжихдээ хууль тогтоомжид заасан хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

6.3.Хуулиар хориглоогүй бол улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орчны бүсэд органик үйлдвэрлэл эрхэлнэ.

6.4.Орцын 95 болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай бүтээгдэхүүнийг органикт тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “эрх” гэсний дараа “, үүрэг” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “шилжилтийн үеийн, эсхүл органик болохыг илэрхийлсэн” гэснийг, 6.1.3 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан бодис, хувиргасан амьд организм, цацрагийн боловсруулалт, өсөлтийн даавар хэрэглээгүй болон” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалт тус тус нэмэх:

“6.1.4.органик үйлдвэрлэл эрхлэхэд үндэсний, эсхүл олон улсын стандартыг хэрэглэх;

6.1.5.баталгаажуулалтын байгууллагыг сонгох;

6.1.6.хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүнээр элсэх хүсэлт гаргах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “7 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчийн үүрэг” гэснийг, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.10 дахь заалт, 7.2, 7.3 дахь хэсэг тус тус нэмэх:

“7.1.2.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу мэдээллийн цахим санд бүртгүүлэх, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

7.1.3.урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж, баталгаажуулалтын байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх, энэ хуулийн 6.6-д заасан мэдээллийн санд тайлан, мэдээг хүргүүлэх;

7.1.4.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

7.1.10.ойн дагалт баялаг, байгалийн ургамлыг түүх ажлыг бусдаар гүйцэтгүүлэх бол холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зааварчилгаа өгч, тэмдэглэл хөглөх.

7.2.Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан энэ хуулийн 7.1.8-д заасан талбайг тогтоож, тодорхойлолт олгоно.

7.3.Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавих шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.8.сүүлийн гурван жилийн хугацаанд энэ хуулийн 8.2-т заасан жагсаалтад орсноос бусад бодисыг хэрэглээгүй, авто зам болон бохирдлын эх үүсвэр, эсхүл органик бус аж ахуйгаас нэг км-ээс багагүй зайтай талбайгаас ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.6.хөрсгүй технологи /гидропоник/ ашиглах;

8.1.7.энэ хуулийн болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, сурталчлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.8 дахь заалт нэмж, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах.

“8.1.8.органик бүтээгдэхүүнтэй харьцах бүх төрлийн гадаргуу, сав, баглаа, боодолд нано бүтэцтэй материал ашиглах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн **ГУРАВДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ШОШГОЛОЛТ, БҮРТГЭЛ”** гэснийг **“БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН, ШОШГО”** гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “тус тус” гэснийг хасаж, төслийн 9.4 дэх хэсгийн “түүнийг байгуулах,” гэсний дараа “бүртгүүлэх,” гэж нэмж, төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.5.Баталгаажуулалтын байгууллага нь эрх бүхий байгууллагаас олгосон давхцалгүй бүртгэлийн дугаартай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.1.органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулах, хэрэгжүүлэх, хянах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.



14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.4, 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.4.энэ хуулийн 15.3-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэлийн байршил, төрөл, мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт зэргийг харгалзан шаардлагатай тохиолдолд шилжилтийн үеийн хугацааг тогтоох;

10.1.5.энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээний хэрэгжилт, тохирлын үнэлгээний тайлан, баталгаажуулалтын гэрчилгээ, шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөө, шаардлагатай бусад мэдээлэл, баримт бичгийг мэдээллийн санд оруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“11 дүгээр зүйл.Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх**

11.1.Үйлдвэрлэл эрхлэгч органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлтийг мэдээллийн санд илгээхдээ дараах шаардлагыг хангасан байна:

- 11.1.1.дотоод хяналтын хуудсыг бөглөх;
- 11.1.2.мэдээллийн санд хэрэглэгчээр бүртгүүлэх маягтыг бөглөх.

11.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчийг хэрэглэгчээр бүртгэж, мэдээллийн санд хандах эрх олгоно.

11.3.Үйлдвэрлэл эрхлэгч мэдээллийн санд бүртгэлтэй баталгаажуулалтын байгууллагаас сонгож, органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг баталгаажуулалтын байгууллагад илгээнэ.

11.4.Баталгаажуулалтын байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.4.1.үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж, хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг байгуулж, хэрэгжилтийг хангуулах;

11.4.2.шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчид шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнд баталгаажуулалтын гэрчилгээг олгож, холбогдох баримт бичгийн хамт мэдээллийн санд илгээх.

11.5.Мэдээллийн сангаас шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн бүртгэгдсэн тухай мэдэгдэл ирснээр үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн тэмдэг хэрэглэх эрх үүснэ.

11.6.Энэ хуулийн 11.4.2-т заасан баталгаажуулалтын гэрчилгээний загварыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.7.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь органик үйлдвэрлэлийн талаарх олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдгийг хэрэглэж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 7

Бүгд: 13

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 6

Бүгд: 12

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Батжаргал:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Органик бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох тохиолдолд гаалийн байгууллага нь тухайн бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгэлтэй эсэхийг шалгаж улсын хилээр нэвтрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 13.5.1 дэх заалтын “илэрхийлсэн” гэсний дараа, 13.5.2 дахь заалтын “дэвсгэртэй” гэсний дараа “гэрчлэх” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.7 дахь хэсэг нэмэх:

“13.7.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.6-д заасан үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7.Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 6

Бүгд: 12

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Батжаргал:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 6  
Бүгд: 12  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Батжаргал:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 6  
Бүгд: 12  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Батжаргал:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.3 дахь хэсэг нэмж, төслийн 14.3 дахь хэсгийн “Импортлогч” гэсний дараа “, экспортлогч” гэж нэмэх:

“14.3.Бөөнөөр нийлүүлсэн органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэлтэй жижиглэн савласан органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэл нь ижил байх ба савласан огноог шошгонд ил харагдахуйц тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

**“15 дугаар зүйл.Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг**

15.1.Органик үйлдвэрлэлийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн нэгж хариуцан гүйцэтгэнэ.

15.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага органик үйлдвэрлэлийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсын "Хөгжлийн зорилтот хөтөлбөр" болон бусад урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн баримт бичигт органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бодлогыг тусгах, салбар хоорондын уялдааг хангах, хэрэгжүүлэх;

15.2.2.энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийн санг байгуулах, шинэчлэх, шаардлагатай бусад мэдээллийн сантай холбох;

15.2.3.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэгчийг мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааг удирдах, холбогдох мэдээллийг олон улсын байгууллагад хүргүүлэх;

15.2.4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн бүтцэд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

15.2.5.органик үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, гишүүний татвар, хандивыг улсын төсвөөс төлөх асуудлыг шийдвэрлэх;

15.2.6.органик салбарын Үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журмыг батлах.

15.3.Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан журамд дараах асуудлыг тусгана:

- 15.4.1.мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх;
- 15.4.2.тариалангийн органик үйлдвэрлэл эрхлэх;
- 15.4.3.органик хүнсийг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх;

15.4.4.зөгийн органик аж ахуй эрхлэх;  
15.4.5.хоол үйлдвэрлэл, үйлчилгээг органик зарчимд нийцүүлэн эрхлэх;  
15.4.6.хүнсний бус органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;  
15.4.7.органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг хэрэглэх, шошголох, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх;

15.4.8.органик бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, тээвэрлэх, экспортлох, импортлох.

15.5.Органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэх асуудлыг энэ хуулийн 15.3-т заасан журам тус бүрд тусгана.

15.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих талаар тухайн орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг мэдээллийн санд оруулна.

15.7.Итгэмжлэлийн байгууллага нь органик бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улстай харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашиглах тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын “органик бүтээгдэхүүнийг” гэсний өмнө “баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, 15.2.1 дэх заалтын “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх шатны боловсролын байгууллагын” гэж, 15.2.3 дахь заалтын “нийлүүлсэн” гэснийг “нийлүүлсэн нь Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу нотлогдсон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бичиг баримт” гэснийг “баримт бичиг” гэж, мөн хэсгийн “хяналт” гэснийг “хяналтыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Ж.Батжаргал танилцуулав.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн тавьсан асуултад хууль санаачлагч, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Батгөмөр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол ногоо төслийн эрх зүйн орчин төслийн менежер Б.Алтанцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Органик бүтээгдэхүүний тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

***1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

***2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.5.10<sup>1</sup> дахь заалтын “6.1.1-д” гэснийг “4.1.2-т” гэж өөрчилж, мөн заалтын “буюу тариалсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 6  
Бүгд: 12  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

***3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

***4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

***5.Органик бүтээгдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:***

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.



Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**6.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн тавьсан асуултад хууль санаачлагч, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал үг хэлэв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Батжаргал:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 39.1.4.5 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.1.4.5.нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад үйлдвэрлэсэн, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй органик бордоог ашиглах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	3
Татгалзсан:	9
Бүгд:	12

25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**7.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**8.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Батжаргал:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь заалтын ““үйлдвэрлэл” гэсний дараа “импорт, экспорт” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
-------------	---

Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

***9.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 46 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 37 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
14 цаг 51 минут.

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Батжаргал:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэг, Хаянгаагийн Болорчулуун, Гочоогийн Ганболд, Наянтайн Ганибал, Гонгорын Дамдинням, Цагаанхүүгийн Идэрбат, Нанзадын Наранбаатар, Цэвэгдоржийн Туваан, Төмөртоогогийн Энхтүвшин, Жигжидийн Батжаргал, Буланы Бейсен гишүүд хүрэлцэн ирж, ирц 57.9 хувьтай байх тул хуралдааныг эхлүүлэе.

Өнөөдрийн хуралдаанаар Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах юм. Хэлэлцэх нэг асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудал байхгүй юу? Тэгвэл хэлэлцэх асуудлаа тогтлоо. Одоо хэлэлцэх асуудалдаа оръё.

**Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсэг Хүнс, хөдөө аж

ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төлөөлөл ирсэн байна. Б.Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Тунгалаг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав, баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч, Отгонбаяр Бордоо, ургамал хамгаалал, хөдөө аж ахуйн зохистой дадлын асуудал хариуцсан мэргэжилтэн, Б.Алтанцэцэг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол ногоо төслийн эрх зүйн орчин төслийн менежер, “Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний нэгдэл” ТББ-ын тэргүүн, судлаач. Ийм ажлын хэсэг байна.

Одоо хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баттөмөр дарга танилцуулга хийнэ.

**Б.Баттөмөр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ундрэм, Анужин, Аубакир, Саранчимэг, Туваан, Энхтүвшин, Адъяаа нараас 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 28-ны 5 дугаар тогтоолоор Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр миний бие ахлан, гишүүнд нь, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ганхуяг, Идэрбат, Цэрэнпунцаг нар ажиллалаа.

Дээрх хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэг 10 гаруй удаа хуралдаж ажлын хэсгийн хурлыг 2 удаа хуралдаж, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн талаар 24 саналын томъёолол, 1 найруулгын саналын томъёолол, хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаар 3 саналын томъёоллыг илтгэн та бүгдэд танилцуулж байна.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт төслүүдийг эрхлэх асуудлын дагуу Төсвийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд ирүүлсэн байна.

Төсөл санаачлагчдаас Хувь хүний орлогын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг буцаан татах саналаа илэрхийлсэн.

Та бүхэнд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гарсан саналын томъёоллын тараасан тул хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүнд баярлалаа. Манай Тилеуханы Аубакир гишүүн, Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүд, мөн хуралдаанд ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу зүйл бүрээр нь хэлэлцье.

Тухайн зүйлүүд дээр саналтай гишүүд саналаа тухай бүр нь илэрхийлж яваарай гэдгийг хэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай, зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу? 1 дүгээр зүйл дээр? Саранчимэг гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Бүгдэд нь өдрийн мэнд. Энэ органик бүтээгдэхүүний тухай хууль батлагдаад бас нэлээдгүй цаг хугацаа өнгөрч байна. Ер нь батлагдсанаас хойш мэдээж энэ нэмэлт, өөрчлөлтүүд орж ирж байгаа л даа. Тэгэхээр яг хууль батлагдаад Монгол Улсын энэ эдийн засгийн хувьд ямар үр өгөөжийг өгөв? Өнөөдрийн энэ яриад байгаа 1 дүгээр зүйл дээр бас тодорхой заалтууд бас байгаад байсан байх. Энэ яг энэ органик бүтээгдэхүүн гэж Монгол Улсад яг албан ёсоор хэдэн бүтээгдэхүүн хүлээн зөвшөөрөгдөхөөр зарлагдав? Энэ талаар бас мэдээлэл авъя. Өнөөдрийн энэ орж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд нь мэдээж энэ хуулийн хүрээнд бас үйлчлэл нь тодорхой хэмжээнд өөрчлөх шаардлагатай учраас энэ нэмэлт, өөрчлөлтүүд орж ирж байгаа байх л даа.

Тэгэхээр эхлээд батлагдсан энэ хуулийнхаа хүрээнд ямар үр дүнд хүрсэн талаараа бас товч мэдээлэл өгөөч.

**Ж.Батжаргал:** Хариултыг ажлын хэсгийн ахлагч өгөх үү? Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

**Б.Баттөмөр:** Би энэ яг хэчнээн бүтээгдэхүүн байна гэдэг дээр нь хариулт өгье. Ямар үр дүнд хүрсэн талаар яамны холбогдох хүмүүс нь мэдээллээ өгье. Органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан гэж байдаг. Энд 2024 оны 1 сарын 5-ны өдрийн байдлаар ижилжилтийн үеийн 53 бүтээгдэхүүн органик гэж, органик бүтээгдэхүүн 311, импортын органик гэж тооцогдох 70 төрлийн бүтээгдэхүүн байгаа юм. Ийм бүтээгдэхүүнүүд байна.

**Ж.Батжаргал:** Ямар үр дүнд хүрсэн талаар яамны холбогдох хүмүүс мэдээлэл өгөх нь зүйтэй байх өнгөрсөн хугацаанд.

Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

**Д.Тунгалаг:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2016 онд Органик хүнсний тухай хууль батлагдсанаас хойш бид нар бол нэлээн үр дүнд хүрсэн байгаа. Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хамгийн гол үр ашиг нь бол ер нь бол байгаль орчинд ээлтэй, химийн бодисын хэрэглээ маш багатай тийм хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихэд оршдог. Мэдээж дэмжлэг урамиууллын чиглэлээр бол хуулийн зохицуулалт маш бага байгаа.

Тийм учраас бас манай аж ахуйн нэгжүүд бол ер нь бол өөрсдийн хүч чармайлтаар өнөөдрийг болтол давхардсан тоогоор бараг 1000 орчим бүтээгдэхүүнийг органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байгаа. Энэ бүртгэл, мэдээллийн санг бас

олон улсын байгууллагын дэмжлэг, тусламжтайгаар ашиглалтад оруулсан.

Үүнээс гадна органик хүнсний органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг бол олон улсын оюуны өмчийн Мадридын хэлэлцээрийн дагуу энэ гэрчлэх тэмдгийг бүртгүүлээд манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол эзэмшигчийн эрхийг авсан байгаа. Үүнээс гадна Монгол Улс бол IFOAM гээд органикийн олон улсын байгууллагад гишүүнээр элссэн байгаа.

Дээрээс нь бид нар манай органик бордоо үйлдвэрлэдэг “Монпеллетс” гээд компани Холбооны Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Итали улсад бол тодорхой хэмжээний бүтээгдэхүүн бол экспортлож байгаа. Үүнээс гадна “Хуба Хаяа”, “Үлэмж органик” гэх мэтчилний компаниуд зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлээд баталгаажуулаад явж байгаа. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Саранчимэг гишүүн.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бид нар маш чухал хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Тэгэхээр энэ органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг бас санаачилж оруулж ирж байгаа гишүүний нэг байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсэг бас сайн ажиллаад, Баттөмөр гишүүн ахлаад өнөөдөр бас дахиж оруулж ирж байгаад бас талархаж байна. Тэгэхээр энэ чуулганаар энэ төслийг хэлэлцэхэд одоо гишүүд энэ органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид үзүүлэх татварын хөнгөлөлт, дэмжлэгийн талаар маш их асууж байсан. Тэгэхээр энэ төсөл санаачлагч гишүүд бид энэ органик бүтээгдэхүүн төрийн оновчтой бодлого зохицуулалт маш хэрэгтэй гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ ажлын хэсэг энэ дээр ямар байр суурь баримталж ажилласан бэ гэсэн ийм нэг асуулт

байна. Дараагийн асуултууд нөгөө зүйл зүйл дээр нь асуугаад явъя. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Баттөмөр гишүүн хариулъя.

**Б.Баттөмөр:** Энэ Органик хүнсний тухай энэ хууль бол Бүтээгдэхүүний тухай хууль үнэхээр их цаг үеэ олсон чухал ийм хуулийг санаачилсан байгаа. Ундрам гишүүн, Сарангэрэл гишүүн гээд эд нар. Энэ дэлхийн чиг хандлага бол ерөөсөө энэ органик бүтээгдэхүүн рүү явж байна л даа. Өнөөдөр бол надад байж байгаа мэдээллээр дэлхийн хэмжээнд гээд тэгэхэд 8 хувь нь хэрэгжиж байгаа хүнсний бүтээгдэхүүн 8 хувь нь органик бүтээгдэхүүн гэж тооцдог, 15 хувь руу зорилт тавиад ажиллаж байгаа.

Өнөөдөр бол Монгол Улсын хэмжээнд нийт бүтээгдэхүүний 0.5 орчим хувь юм уу ийм хэмжээнд гэсэн ийм судалгааг би харсан ийм байдаг. Бидний нөгөө барьж ажиллаж байгаа “Алсын хараа 2050”-д бол 2030 он гэхэд нийт хүнсний бүтээгдэхүүнийхээ 5 хувийг органик болгоё гэсэн ийм зорилт тавьж ажиллаж байгаа.

Тэгэхээр өнөөдөр 0.5 хувь болно гэдэг чинь ер нь их л том зорилт байгаа. Үлдэж байгаа 5, 6 жилийн хугацаанд энд хүрэхэд их сайн ажиллах ийм шаардлагатай. Энэ ер нь бол энэ хүнс бол ер нь өвчлөлийн гол сая хийсэн судалгаа байгаа юм л даа. Энэ хоол боловсруулах эрхтэн энэ хоол боловсруулахад оролцдог эрхтнүүдийн өвчлөлийг нь үндсэндээ 70 орчим, 71, 72 орчим хувь нь энэ хүнстэй холбоотой гэсэн судалгаа гаргасан байгаа юм. Манайд орж ирж байгаа энэ органик бус янз бүрийн бордоо хэрэглэж байна, янз бүрийн бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа. Бид чинь ходоодыг нь хоол боловсруулах эрхтний өвчлөлөөр дэлхийд тэргүүлж байгаа, нас баралтаар тэргүүлж байгаа тэр учраас тийм учраас үүнийг шалтгаан нь бол юутай холбоотой гэхээр хоол хүнстэй холбоотой нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол юу вэ гэхээр ер нь бол Монголчуудын амьдрал. Монгол улс хөгжлийн агуу их том потенциалтай, монголчуудын амьдрал дээшилж байгаа. Дундаж давхарга бол дээшилнэ. Цаашидаа үр хүүхдүүдийнхээ амьдралд бид нар ирээдүйгээ их томоор харах ёстой. Ер нь сургуулийн хүүхдүүдийн энэ бага насны хүүхдийн, сургуулийн өмнөх боловсролын хүүхэд байгууллагад хүмүүжиж байгаа энэ хүүхдүүдийн хоолыг энэ органик тал руу нь явуулах ийм зайлшгүй шаардлага үүсэж байгаа.

Тийм учраас энэ хуулийг болих дэмжиж бид нар ингэж ажиллаж байгаа. Үүн дээр түрүүн жишээ нь нэгдсэн чуулган дээр ярихад их олон татварын хөнгөлөлтүүд байсан юм. Нэмэгдсэн өртгийн албан татвар, хувь хүнийх, тэгээд дээрээс нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, материал худалдаж авах хуулиуд их хөнгөлөлтүүд байсан юм. Үүнийг бол дэмий юм гээд ингээд хууль санаачлагч нь өөрөө, Ундрам гишүүн өөрөө үүнийг татаж аваад зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварт тухайн бүтээгдэхүүнийг борлуулсан тохиолдолд борлуулалтын орлогын 90 хүртэл хувийг хөнгөлье гэж байгаа юм. Ингээд үзэхээр юу вэ гэхээр ер нь бол төрөөс энэ ямар нэгэн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихдээ 3 төрлийн зүйлээр дэмждэг.

Нэгдүгээрт нь бол юу вэ гэхээр татварын бодлогоор.

Хоёрдугаарт нь урт хугацаатай, бага хүүтэй зээлээр.

Гуравдугаарт нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдаж авдаг. Энэ 3 концепт, энэ 3 чиглэл энэ хуульд бол багтсан байж байгаа. Ингэж бол ажиллалаа гэж хариулъя.

**Ж.Батжаргал:** Нэмэлт хариулт бий юу? 1 дүгээр зүйл дээр ажлын

хэсгээс 1 саналын томъёолол бэлтгэсэн байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “дэмжлэг үзүүлэх” гэсний өмнө “төрөөс” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Органик” гэсний дараах “хүнсний” гэснийг хасах. Ийм саналын томъёолол байна. Санал хураалт.

53.8 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулттай саналтай гишүүд байна уу? Ганибал гишүүн байна.

**Н.Ганибал:** Бид нар органик хүнсний хэрэглээ ний нуугүй хэлэхэд Монгол улсад өнөөдрийн энэ иргэдийн орлого, энэ цалин, тэтгэвэр, тэтгэмж бүх нийтээрээ органик хүнс хэрэглэх ямар ч боломжгүй л ийм нийгэмд амьдарч байгаа юм. Бид нар Монгол улсын энэ аж ахуйн нэгжүүдийн гол органик хүнс үйлдвэрлэж байгаа, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний зах зээл нь мэдээж өндөр хөгжсөн, худалдан авах чадвартай энэ улс орнууд руу чиглэсэн ийм л үйлдвэрлэлийг манай аж ахуйн нэгжүүд хийж байгаа байх. Тэрнээс яг дотоодын хэрэглээнд яг энэ органик хүнс, органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлээд ний нуугүй худалдаж авах чадамж байхгүй.

Яагаад гэхээр органик бүтээгдэхүүн бол бусад бүтээгдэхүүнүүдээс илүү өндөр өртөгтэй гардаг. Энэ асуудлууд дээр бид нар өнөөдөр төрийн дэмжлэгийн асуудлыг бас тодотгож өгч байна л даа. Тэгэхдээ бид өнөөдөр яг энэ бүтээгдэхүүн өөрөө зах зээлийнхээ зарчмаар үнэ цэнтэй бүтээгдэхүүн болоод зах зээлээ олох энэ асуудал дээр бид нар зайлиггүй бас нэмж оруулах нэг асуудал нь энэ экспортын чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн энэ асуудал дээр Хөдөө аж ахуйн яам бодит дэмжлэг үзүүлж байж бүтээгдэхүүн өөрөө олон улсын зах зээлд өөрийн гэсэн байр сууриа

олж авах байх л даа. Энэ гадаад худалдааны асуудал болох байх.

Тэгэхээр энэ асуудлуудыг энэ бас энэ заалт зүйл юунуудын, 3 дугаар зүйл дээрээ гэх юм уу 1 дээрээ юм уу бас ингэж тодотгож зайлиггүй оруулж өгвөл бид нар органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл бол бодит зах зээлийнхээ тэр дээр өөрийн гэсэн байр сууриа олох ийм боломжоор л хангагдана гэж харагдаад байгаа юм. Энэ дээр та бүхэн бас ямар бодолтой байна?

**Ж.Батжаргал:** 2 дугаар зүйл маань органик бүтээгдэхүүний тухай хууль тогтоомжийн асуудал байгаа. Тийм учраас таны наад гаргаж байгаа санал бол тухайлсан зүйл, заалт дээрээ яригддаг.

2 дугаар зүйлтэй холбогдуулж боловсрогдсон саналын томъёолол байхгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 1 санал бэлтгэгдэж орж ирсэн. Тийм биз дээ? Тийм тийм.

Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Энэ хууль нь хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгацыг үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2. Энэ хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа шилжилтийн үеийн органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд хамаарна.

3.3.Амьтны тухай хуулийн 4.1.7-д заасан агнуурын амьтны түүхий эдээр органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.”. Санал хураалт.

61.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 2 санал бэлтгэгдсэн.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1. “органик үйлдвэрлэл” гэж шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд нөөцийг зохистой ашиглах, экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалахад чиглэсэн уламжлалт арга барил, биологи ба механик арга технологийг хослуулан эрхлэхийг;

4.1.2. “органик бүтээгдэхүүн” гэж зохиомол аргаар нийлэгжүүлсэн нэмэлт бодис, эрдэс бордоо, пестицид, антибиотик, өсөлтийн даавар, хувиргасан амьд организм, цацраг туяа хэрэглээгүй энэ хуулийн 4.1.1-д заасан үйлдвэрлэлийн үр дүнг;” санал хураалт.

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7, 4.1.8, 4.1.9 дэх заалт нэмэх:

“4.1.7. “органик болохыг илэрхийлсэн тэмдэг” гэж эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн органик болон шилжилтийн үеийн түүхий эд, бүтээгдэхүүнийг гэрчилж, шошгод байршуулсан тэмдгийг;

4.1.8. “урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэж органик бүтээгдэхүүн

нь органик бус бүтээгдэхүүнтэй холилдох, энэ хуулийн 8.2-т заасан органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн бодисын жагсаалтад зааснаас өөр бодисоор бохирдох эрсдэлээс зайлсхийхийг;

4.1.9. “шошго” гэж органик бүтээгдэхүүний оноосон болон худалдааны нэр, органик үйлдвэрлэлийн талаар бичсэн, хэвлэсэн, зурсан, товойлгосон, сийлсэн аливаа үг, бичиглэл, мэдэгдэл, тэмдэг, дардас, зураг, тухайн бүтээгдэхүүнийг дагалдах баримт бичиг, хуудас, зүүлт, хавчуурга, дардас, бөгж, хүзүүвчийг.” санал хураалт.

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 1 саналын томъёолол бэлтгэгдсэн байна.

Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“5 дугаар зүйл. Органик үйлдвэрлэлд баримтлах зарчим**

5.1.Органик үйлдвэрлэлд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүн амын одоо ба ирээдүйд эрүүл, аюулгүй оршин тогтнох, тэдгээрийн дархлаа, дасан зохицох чадварыг дэмжих, нөхөн сэргээх;

5.1.2.экосистемийн тэнцвэрийг хадгалах, биологийн олон янз байдлыг дэмжих, уламжлалт соёл, ёс заншлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нөөцийн тогтвортой байдлыг хангах;

5.1.3.зах зээлийн өрсөлдөөн, үйлдвэрлэлийн бүх үе шатанд шударга, энэрэнгүй ёсыг баримтлах, гадаад орцын хэрэглээг хязгаарлах, мэдлэгээ хуваалцах;



5.1.4.бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалах, нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн арга технологиор үйлдвэрлэл эрхлэх;

5.1.5.уламжлалт мэдлэгийг шинжлэх ухааны ололттой хослуулан органик үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэхдээ урьдчилсан үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, ил тод, нээлттэй шийдвэр гаргах;

5.1.6.шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийг сайн дурын үндсэн дээр эрхлэх.” санал хураалт.

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 2 саналын томъёолол бэлтгэсэн байна.

Төслийн **ХОЁРДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ЭРХЛЭГЧИЙН”** гэснийг **“ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА”** гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

**“6 дугаар зүйл. Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага**

6.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь дараах нийтлэг шаардлагыг хангана:

6.1.1.энэ хуульд заасан шаардлага, журмыг баримталж органик үйлдвэрлэлд шилжих;

6.1.2.органик үйлдвэрлэлд шилжихдээ энэ хуулийн 8.2-т зааснаас бусад бодисыг тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэхээ зогсоох;

6.1.3.усны бохирдлоос сэргийлэх, цас, борооны усыг ашиглах,

хаягдал багатай, эсхүл хаягдалгүй усны технологи ашиглах;

6.1.4.биотехникийн болон биологийн олон янз байдлын чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.1.5.өөрийн болон хөрш зэргэлдээ, нийтийн эзэмшлийн газрын байгаль орчин, эд зүйлсийг хамгаалах.

6.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь органик үйлдвэрлэлд шилжихдээ хууль тогтоомжид заасан хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

6.3.Хуулиар хориглоогүй бол улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орчны бүсэд органик үйлдвэрлэл эрхэлнэ.

6.4.Орцын 95 болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай бүтээгдэхүүнийг органикт тооцно.”. Санал хураалт.

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “эрх” гэсний дараа “; үүрэг” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “шилжилтийн үеийн, эсхүл органик болохыг илэрхийлсэн” гэснийг, 6.1.3 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан бодис, хувиргасан амьд организм, цацрагийн боловсруулалт, өсөлтийн даавар хэрэглээгүй болон” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалт тус тус нэмэх:

“6.1.4.органик үйлдвэрлэл эрхлэхэд үндэсний, эсхүл олон улсын стандартыг хэрэглэх;

6.1.5.баталгаажуулалтын байгууллагыг сонгох;

6.1.6.хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүнээр элсэх хүсэлт гаргах.”. Санал хураалт.

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 2 санал бэлтгэсэн байна.

Төслийн “7 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчийн үүрэг” гэснийг, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.10 дахь заалт, 7.2, 7.3 дахь хэсэг тус тус нэмэх:

“7.1.2.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу мэдээллийн цахим санд бүртгүүлэх, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

7.1.3.урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж, баталгаажуулалтын байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх, энэ хуулийн 6.6-д заасан мэдээллийн санд тайлан, мэдээг хүргүүлэх;

7.1.4.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

7.1.10.ойн дагалт баялаг, байгалийн ургамлыг түүх ажлыг бусдаар гүйцэтгүүлэх бол холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зааварчилгаа өгч, тэмдэглэл хөтлөх.

7.2.Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан энэ хуулийн 7.1.8-д заасан талбайг тогтоож, тодорхойлолт олгоно.

7.3.Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавих шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”. Санал хураалт. Санал хураалт. Уул нь цохисон л юм даа. Алахыг нь хуга цохичихвол балай юм болно шүү дээ.

64.3 хувиар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.8.сүүлийн гурван жилийн хугацаанд энэ хуулийн 8.2-т заасан жагсаалтад орсноос бусад бодисыг хэрэглээгүй, авто зам болон бохирдлын эх үүсвэр, эсхүл органик бус аж ахуйгаас нэг км-ээс багагүй зайтай талбайгаас ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх;”. Санал хураалт.

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс 2 санал бэлтгэсэн байна.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.6.хөрсгүй технологи /гидропоник/ ашиглах;

8.1.7.энэ хуулийн болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, сурталчлах;”. Санал хураалт.

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.8 дахь заалт нэмж, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах.

“8.1.8.органик бүтээгдэхүүнтэй харьцах бүх төрлийн гадаргуу, сав, баглаа, боодолд нано бүтэцтэй материал ашиглах.”. Санал хураалт.

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулттай саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс 1 санал бэлтгэгдсэн байна.

Төслийн **ГУРАВДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ШОШГОЛОЛТ, БҮРТГЭЛ”** гэснийг **“БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН, ШОШГО”** гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “тус тус” гэснийг хасаж, төслийн 9.4 дэх хэсгийн “түүнийг байгуулах,” гэсний дараа “бүртгүүлэх,” гэж нэмж, төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.5.Баталгаажуулалтын байгууллага нь эрх бүхий байгууллагаас олгосон давхцалгүй бүртгэлийн дугаартай байна.”. Санал хураалт.

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 2 санал бэлтгэгдсэн байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.1.органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулах, хэрэгжүүлэх, хянах;”. Санал хураалт.

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.4, 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.4.энэ хуулийн 15.3-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэлийн байршил, төрөл, мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт зэргийг харгалзан шаардлагатай

тохиолдолд шилжилтийн үеийн хугацааг тогтоох;

10.1.5.энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээний хэрэгжилт, тохирлын үнэлгээний тайлан, баталгаажуулалтын гэрчилгээ, шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөө, шаардлагатай бусад мэдээлэл, баримт бичгийг мэдээллийн санд оруулах;”. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 1 санал бэлтгэсэн байна.

Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“11 дүгээр зүйл.Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх**

11.1.Үйлдвэрлэл эрхлэгч органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлтийг мэдээллийн санд илгээхдээ дараах шаардлагыг хангасан байна:

11.1.1.дотоод хяналтын хуудсыг бөглөх;

11.1.2.мэдээллийн санд хэрэглэгчээр бүртгүүлэх маягыг бөглөх.

11.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчийг хэрэглэгчээр бүртгэж, мэдээллийн санд хандах эрх олгоно.

11.3.Үйлдвэрлэл эрхлэгч мэдээллийн санд бүртгэлтэй баталгаажуулалтын байгууллагаас сонгож, органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлт, холбогдох бусад

мэдээллийг баталгаажуулалтын байгууллагад илгээнэ.

**11.4.Баталгаажуулалтын байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

**11.4.1.үйлдвэрлэл**

эрхлэгчийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж, хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг байгуулж, хэрэгжилтийг хангуулах;

**11.4.2.шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчид шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнд баталгаажуулалтын гэрчилгээг олгож, холбогдох баримт бичгийн хамт мэдээллийн санд илгээх.**

**11.5.Мэдээллийн сангаас шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн бүртгэгдсэн тухай мэдэгдэл ирснээр үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн тэмдэг хэрэглэх эрх үүснэ.**

**11.6.Энэ хуулийн 11.4.2-т заасан баталгаажуулалтын гэрчилгээний загварыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.**

**11.7.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь органик үйлдвэрлэлийн талаарх олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдгийг хэрэглэж болно.”. Тийм байна. Баттөмөр дарга, Мөнхцэцэг гишүүн.**

11.7 дээр.

**Г.Мөнхцэцэг:** Тийм 11.7 дээр байна л даа. Энэ уншигдахгүй байгаад байна. Органик үйлдвэрлэл эрхлэгч нь органик үйлдвэрлэлийн талаарх олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэсэн бол Монгол Улсын органик болохыг илэрхийлсэн тэмдгийг хэрэглэж болно гээд үг

орхичихсон уу? Найруулгыг нь жоохон засвар байгаад байх шиг байна. Үүн дээр, органик бүтээгдэхүүн болохыг илэрхийлсэн тэмдгийг хэрэглэж болно гэдэг юм уу тээ. Органик тийм найруулгын алдаа, засвар байгаад байх шиг байна.

**Ж.Батжаргал:** Монгол Улсын органик бүтээгдэхүүн болохыг илэрхийлсэн.

**Г.Мөнхцэцэг:** Тийм, Монгол Улсын гээд л заавал, ер нь бол органик бүтээгдэхүүн болох нь угаасаа Монгол Улсын л ойлгомжтой шүү дээ. Тэгэхээр энэ заавал их тийм айхтар Монгол Улсын органик бүтээгд органик гэж найруулгын жоохон засвар оруулах.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн. Баттөмөр гишүүний микрофоныг өгөөрэй.

**Б.Баттөмөр:** Үүн дээр манай ажлын хэсгийнхэн үзээдэхье дээ. Найруулгын шинж чанартай юу байж болох вэ тийм ээ, тийм. Бид нар энд хүлээж аваад найруулгыг нь засвар хийчихье.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн хэддүгээр микрофон уу? Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

**Д.Тунгалаг:** Хэн гишүүн бэ? Хэн гишүүн бэ? Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Органик болохыг илэрхийлсэн тэмдэг гэж тодорхойлолт байгаа. Тэгэхээр Монгол Улсын гэдгийг нь хасчихъя. Тэгэхээр ерөнхийдөө уншигдахаар байна.

**Ж.Батжаргал:** Аваад шууд органик үйлдвэрлэл эрхлэгч нь органик үйлдвэрлэлийн талаарх олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдгийг хэрэглэж болно гэж өөрчлөгдлөө. Мөн үү?

**Д.Тунгалаг:** Тийм.

**Ж.Батжаргал:** Санал хураалт.

Хөөе 46.2 хувь болж байна. Санал гаргах гишүүн байна уу? Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Сая дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Дахиж санал хурааж өгнө үү гэж.

**Ж.Батжаргал:** Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгөөрэй. Та санал хэлэх юм уу? Гишүүдийг дууд тэр Ганболд, Энхтүвшин эд нарыг дууд даа. Яасан? Үгүй ээ үгүй яах юм энд ойрхон байгаа. Туваан гишүүн санал гаргая.

**Ц.Туваан:** Ганибал гишүүний санал хураалтыг хүчингүй болгож өгөөч гэсэн саналыг дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж эсрэг гарчих юм. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

**Ж.Батжаргал:** Саяын санал хураалтыг хүчингүй болгох саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Туваан гишүүний саналаар.

53.8 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болголоо.

Одоо түрүүн уншигдсан саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Одоо чинь 12 дугаар зүйл үү?

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 1 санал бэлтгэгдсэн байна.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Органик бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох тохиолдолд гаалийн байгууллага нь тухайн

бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгэлтэй эсэхийг шалгаж улсын хилээр нэвтрүүлнэ.”. Санал хураалт. Санал хураалт шүү гишүүд ээ.

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд бий юу? Алга байна. Ажлын хэсгээс 2 санал бэлтгэгдсэн байна.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 13.5.1 дэх заалтын “илэрхийлсэн” гэсний дараа, 13.5.2 дахь заалтын “дэвсгэртэй” гэсний дараа “гэрчлэх” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.7 дахь хэсэг нэмэх:

“13.7.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.6-д заасан үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулахгүй. Санал хураалт.

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7.Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”. Санал хураалт.

Туваан гишүүн санал хэлье.

**Ц.Туваан:** Нөгөө төхөөрөмжийн саналыг гаргаж байна. Хүчингүй болгож өгнө үү.

**Ж.Батжаргал:** Саяын санал хураалтыг хүчингүй болгох дахин санал хураалт явуулах юм уу? Асууя Жавхлан гишүүний микрофоныг өгөөрэй.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Энэ саяын санал хураалт хийгдэхэд 12.3 гээд заалт “органик бүтээгдэхүүнийг импортлох,

экспортлох тохиолдолд гаалийн байгууллага нь тухайн бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгэгдсэн эсэхийг шалгаж улсын хилээр нэвтрүүлнэ” гээд. Хэрвээ мэдээллийн санд бүртгэгдээгүй бол гааль үүнийг бүртгэж авах уу, гаалиар, улсын хилээр нэвтрүүлэхгүй гэсэн үг үү, оруулахдаа ч, гаргахдаа ч? Энэ чинь хилийн хориг болж байна уу, хиймэл хориг болж байна уу? Өмнө нь бас витаминь нэг ийм асуудал дээр бас ийм үл ойлголцох байдал үүсээд бөөн юм болоод буцаад залруулсан шүү. Хуучин заалт нь уг нь их хэвийн л аль аль талынхаа үйл ажиллагаа дээр саад болохооргүй л заалт байсан юм байна лээ. Үүнийг яг юу гэж ойлгох вэ? Гаалийн байгууллага үүнийг яаж хэрэгжүүлэх вэ?

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгээс тайлбар, хариулт. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

**Д.Тунгалаг:** Жавхлан гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө өнөөдрийн яг эрх зүйн зохицуулалтын хувьд бол гаалийн байгууллага бол органик бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал дээр ямар нэгэн чиг үүрэг хэрэгжүүлэхгүй байгаа. Монгол Улсад худалдаалагдаж байгаа органик бүтээгдэхүүнүүд бол уул нь мэдээллийн санд бүртгүүлээд, бүртгүүлсний дараа худалдаанд гарч нийт хэрэгцээнд нийлүүлэгдвэл илүү хэрэглэгчдэд баталгаажсан бүтээгдэхүүн очих тийм боломж бүрдээд байгаа юм.

Гэтэл манай импортлогчид органик хүнснийг улсын хилээр нэвтрүүлээд оруулж ирсэн ч гэсэн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэхгүй байгаа. Тэгэхээр гаалийн бүрдүүлэлт хийгээд ороод ирчихсэн бүтээгдэхүүнийг бид нар дараа нь мэдээллийн санд бүртгүүлнэ гэхээр импортлогчид ямар ч үүрэг хүлээхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр улсын хил дээр яг хяналт шалгалт, хорио цээрийн хяналт шалгалт явж байх үед органик бүтээгдэхүүн байх юм бол урьдчилаад бүтээгдэхүүнээ мэдээллийн санд бүртгүүлсэн байх

шаардлагыг тавиад, бүртгүүлсэн тохиолдолд гаалийн байгууллага улсын хилээр чөлөөтэй нэвтрүүлэх тийм боломж бүрдэх юм.

**Ж.Батжаргал:** Энэ асуудлыг ажлын хэсэг дараагийн хэлэлцүүлгийн явцдаа анзаараад эрх зүйн төвөгшилгүй байх тэр бололцоо, боломжийг нь анзаараадхаарай гэж хэлье.

Өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэж санал гаргасан Туваан гишүүний саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Өмнөх санал хураалт хүчингүй болсонтой холбогдуулаад түрүүн уншсан саналын томъёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

Өөе, биш ээ биш тэр чинь өмнөх нь, өнгөрчихсөн байхгүй юу даа. Мөнхцэцэг гишүүн. Та хэд анхаараадах л даа жосохон. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгөөрэй.

**Г.Мөнхцэцэг:** Саяын санал хураалтад миний төхөөрөмж ажиллаагүй тул дахин санал хураалт явуулж өгнө үү гэж хүсэлт гаргаж байна.

**Ж.Батжаргал:** Мөнхцэцэг гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох саналын томъёоллоор санал хураалт. Одоо саналаа өгөөрэй хөөе.

58.3 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болголоо.

Өмнөх санал хураалт хүчингүй болсон тул түрүүн уншсан саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя.

Болохгүй юм байна. Санал хэлэх гишүүн бий юу? Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Би дэмжиж санал өгсөн байсан. Төхөөрөмж ажиллаагүй. Дахин санал хурааж өгнө үү.

**Ж.Батжаргал:** Бейсен гишүүний саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болгох саналын томъёоллоор санал хураалт.

63.6 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болголоо. Одоо өмнө уншсан саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14 дэх нь мөн үү? Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 1 санал бэлтгэгдсэн байна.

Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.3 дахь хэсэг нэмж, төслийн 14.3 дахь хэсгийн “Импортлогч” гэсний дараа “, экспортлогч” гэж нэмэх:

“14.3.Бөөнөөр нийлүүлсэн органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэлтэй жижиглэн савласан органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэл нь ижил байх ба савласан огноог шошгонд ил харагдахуйц тусгана.”. Санал хураалт.

63.6 хувир дэмжигдлээ.

Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

**“15 дугаар зүйл. Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг**

15.1.Органик үйлдвэрлэлийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө

аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн нэгж хариуцан гүйцэтгэнэ.

15.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага органик үйлдвэрлэлийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсын “Хөгжлийн зорилтот хөтөлбөр” болон бусад урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн баримт бичигт органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бодлогыг тусгах, салбар хоорондын уялдааг хангах, хэрэгжүүлэх;

15.2.2.энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийн санг байгуулах, шинэчлэх, шаардлагатай бусад мэдээллийн сантай холбох;

15.2.3.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэгчийг мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааг удирдах, холбогдох мэдээллийг олон улсын байгууллагад хүргүүлэх;

15.2.4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн бүтэцэд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

15.2.5.органик үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, гишүүний татвар, хандивыг улсын төсвөөс төлөх асуудлыг шийдвэрлэх;

15.2.6.органик салбарын Үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журмыг батлах.

15.3.Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан журамд дараах асуудлыг тусгана:

15.4.1.мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.2.тариалангийн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.3.органик хүнсийг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх;

15.4.4.зөгийн органик аж ахуй эрхлэх;

15.4.5.хоол үйлдвэрлэл, үйлчилгээг органик зарчимд нийцүүлэн эрхлэх;

15.4.6.хүнсний бус органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;

15.4.7.органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг хэрэглэх, шошголох, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх;

15.4.8.органик бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, тээвэрлэх, экспортлох, импортлох.

15.5.Органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэх асуудлыг энэ хуулийн 15.3-т заасан журам тус бүрд тусгана.

15.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих талаар тухайн орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг мэдээллийн санд оруулна.

15.7.Итгэмжлэлийн байгууллага нь органик бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улстай харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг хариуцна. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоё. Мөнхцэцэг гишүүн цуцалъя энд

санал байна. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгөөрэй.

**Г.Мөнхцэцэг:** Энэ 15 дугаар зүйл тэгээд өмнөх зүйлүүд дээр ч гэсэн нэлээн тийм найруулгын юмнууд бас байгаад байна. Бид нар хэдийгээр агуулга нь байгаад байгаа боловч бичиглэлийн хувьд бас яг тийм хуулийн дагуу бичигдэх юман дээр бас жоохон анхаарч ажиллахгүй бол энэ дээр үндсэндээ энэ 15 дугаар зүйл гэхэд л ингээд л энэ саяын хураалгаж байгаа 15.2.1 гэхэд л энэ жигтэйхэн урт өгүүлбэр зохиол бичиж байгаа юм шиг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хөгжлийн зорилт, хөтөлбөр болон бусад юмтай уяна гээд энэ чинь угаасаа л ингээд л бодлогын бичиг баримт нь байгаа юм чинь холбогдох бичиг баримттай нь л уялдуулна гээд арай жоохон цомхон болгоод найруулгын хувьд бас нэлээн олон найруулгын шинжтэй засваруудыг хиймээр юм шиг харагдаад байх юм. Үүн дээр манайхан бас жоохон ажиллаад өгөөч. Ажлын хэсэг ажилласан л байна л.

Гэхдээ бас холбогдох яам юмнууд нь бас ингээд ажиллахгүй бол нэг л их сунжирсан нэг л судалгааны нэгж байгуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх гээд л. Энэ чинь угаасаа ойлгомжтой юмыг хэтэрхий их олон зүйлчлэл болгоод оруулаад ирчихсэн юм гэж харагдаж байна. Шинээр бас нэр томъёо оруулаад ирчихсэн тээ. Шошголох гэж ямар нэр Монгол үг байдаг юм? Энэ чинь хаяглах, шошгожуулах юу гэдэг юм ийм жоохон найруулгын хувьд энэ хуулийг ер нь бас жоохон ажиллахгүй бол бас л тийм хэтэрхий сунжирсан болоод, дээр нь тийм алдаа мадагтай л нэг тийм өгүүлбэрийн бүтэц, зохион байгуулалтын хувьд ч гэсэн арай л өөр бас уншигдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр манай ажлын хэсэг жоохон анхаараад ажиллачих боломж байгаа юу үгүй юу.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсэг хэлэлцүүлэгт бэлтгэх явцдаа саяын хэлж



байгаа саналыг анхаарна биз. Гэхдээ бас яг мэргэжлийн нэр томъёолууд байх шиг байна. Тэр шошголох энэ тэр гэдэг үг тийм агуулгаар ороод яваад байгаа юм уу гэж би ингэж ойлгоод байна.

Түрүүний уншсан саналын томъёоллоор санал хураалт.

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашиглах тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь заалтыг хасах. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

63.6 хувийн саналаар дэмжигдлээ. Мөн биз дээ?

Төслийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын “органик бүтээгдэхүүнийг” гэсний өмнө “баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, 15.2.1 дэх заалтын “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх шатны боловсролын байгууллагын” гэж, 15.2.3 дахь заалтын “нийлүүлсэн” гэснийг “нийлүүлсэн нь Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу нотлогдсон” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд бий юү? Алга байна. Ажлын хэсгээс санал байхгүй.

Одоо хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд бий юү? Алга байна. Ажлын хэсгээс санал байхгүй.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай

гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 2 санал бэлтгэгдсэн байна.

Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал хураалт.

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёолол, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх. Найруулгын санал. Энийгээ санал хураах юм уу? Ерөнхий саяын хэлсэн томъёоллоор санал хураалт.

63.6 хувийн саналаар дэмжигдлээ. Найруулгын санал байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бичиг баримт” гэснийг “баримт бичиг” гэж, мөн хэсгийн “хяналт” гэснийг “хяналтыг” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Одоо хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эрхлэх асуудлын дагуу Төсвийн байнгын хороо авч хэлэлцсэн байгаа.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд би танилцуулъя. Тарчихсан даа. Униших хэрэг байна уу, Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг? Айн юутай үгүй ээ үгүй тэр ч хамаагүй л дээ. Бусад нь өнөө Төсвийн байнгын хороогоор орохгүй иүүд манайхаар явж байгаа хуулийн төслүүд байхгүй юу. Төсвийн байнгын хороогоор орох ёстой хуулийн төслүүдийг нь тэднийхээр оруулаад санал, дүгнэлтийг нь манайх татаж авч байгаа ийм л зүйл.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт тарчихсан. Тийм учраас танилцуулсанд тооцъё тэгэх үү? Тэгж тооцлоо. Жавхлан сайд, Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Энэ дагасан хууль болон хуулийн үндсэн заалтууд дээр бас 2, 3 юмнууд байна. Үүнийг та хэд маань бас эргээж хараач ээ гэж. Төсвийн байнгын хороон дээр дагасан хуулиудаас тэр Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Импортын татварын тухай хууль, нэг нь НӨАТ-тай холбоотой хуулиудыг татаж авахаар ингээж шийдсэн байсан. Ингээд хууль санаачлагч бас татаж авч байгаа юм байна. Энд талархлаа. Өөр нэг асуудлыг бас хөндөж ярилцсан. Эргээж харах талаар бас Төсвийн байнгын хорооны протоколд тусгагдсан байгаа.

Тэр нь юу вэ гэхээр энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай гээд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн тэдийн тэд 4.1.2-т заасан органик

бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ноогдох албан татварыг 90 хувиар хөнгөлнө гээд. Үүнийгээ эргээж хараач. Би ингээж ойлгоод байгаа юм органик бүтээгдэхүүн гэдэг чинь зөвхөн Монгол Улсад яригдаж байгаа асуудал биш, дэлхий нийтэд энэ органик бүтээгдэхүүн гэж энэ хандлага энэ интеграцид Монгол Улсад нэгдэж орох ийм алхам ийм хуулиа шинэчилж оруулж ирж байна гэж ингээж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл, энэ хаана ч зорилтот зах зээл л байдаг. Европт ч тэр, Америкт ч тэр. Түүн дээр ингээд хөнгөлөлт үзүүлээд тэгээд яг масс үйлдвэрлэлээрээ ард түмнээ хангаж байгаа тэр хэсэг дээр ямар ч хөнгөлөлтүүд байхгүй. Үүнийг ингээж ялгаварлан гадуурхах ийм юм байж боломгүй байгаад байгаа юм.

Дээрээс нь энэ органик бүтээгдэхүүн гэдэг энэ тодорхойлолтууд дээрээ бас асуудал байна. Тэр 12.3 дээр түрүүн Баттөмөр гишүүн анзаарчихлаа, ойлгочихлоо гэж ойлгож байна. Тэр дээр бас эргээд хараадхаарай. Тэр 13.7-д жишээ нь органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Дэлхий нийтийн интеграцид орчихсон, энэ стандартын гадна талд олон улс бас хардаг ийм стандарт тогтчихсон ийм юман дээр Засгийн газар, Улсын Их Хурлын түвшинд бараг яригдах асуудлыг нэг сайд шийдээд, энэ шийдсэн аргачлал, энэ журмынх чинь татварын асуудлыг давхар шийдчихэж байгаа байхгүй юу. Хэн 90 хувийн хөнгөлөлтөд хамрагдах вэ гэдгийг зүгээр татварын асуудал эрхэлсэн сайд биш, шал өөр сайд үүнийг шийддэг ингээд энэ заалтууд нь хоорондоо уялдаа холбоогүй ийм юм болчихоод байна. Тийм учраас Ганивал гишүүн ээ та наад тоглохоо дараа нь больчих л доо.

Тийм учраас энэ Аж ахуйн нэгжийн орлогын татвартай хуулиа тэр бусад татвартай холбоотой асуудлуудтайгаа татсан шигээ энийг

эргээд татах асуудлыг гараадхаач. Энэ хөнгөлөлт, чөлөөлөлт байж болохгүй. Дээрээс нь бүр хугацаагүй тавьчихаар бүр энд ийм асуудал үүснэ. Бүр энэ дээр мораль хазард /moral hazard/ үүснэ шүү. Органик бүтээгдэхүүний шошго авдаг ийм хар зах зээл үүснэ. Энэ бол бүүр энэ ногоон автобусны дараагийн боловсронгуй ийм шинэ, цоо шинэ, ийм бүүр том зах зээл үүснэ шүү. Тэр шошго авч энэ 90 хувийн хөнгөлөлт, чөлөөлөлт гэдэг асар том хөнгөлөлт, чөлөөлөлт. Бид төсвийн орлогуудаа яаж бүрдүүлье гэж байхад шинэ хууль ярилцаж байгаа болгон дээр ийм татварын хөнгөлөлт, чөлөөлөлт орж ирэх юм бол бид чинь, энэ улс орон чинь ер нь яаж явах юм бэ? Тийм учраас энэ ийм зөрчилтэй асуудлуудыг эргэж хараад, сайн хууль гаргацгаая л гэж би уриалмаар байгаа юм. Үүнийг яаж шийдэх байгаа юм. Эргэж дэмжихгүй байх юм уу, эсвэл хууль санаачлагч маань эргэж татаж авах юм уу? Үүнийг хараад өгөөч. Тэр 12.3 одоо бүүр болохгүй шүү. Түрүүн тэр аль яамнаас хэн тайлбарлаад байна? Тэр бүүр органик бүтээгдэхүүнийг оруулж болохгүй шүү гаалийнхан бүүр хойш нь шидчихээрэй, хилийн цаана байлгаж байгаад бүүр хөлдчихсөн хойно нь мэдээллийн санд оруулаад тэр.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Жавхлан сайд ийм саналтай байна. Ажлын хэсэг Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Энэ үндсэндээ 4, 5 тийм чөлөөлөлт, хөнгөлөлт үзүүлэхээр орж ирсэн юм. Би бас ажлын хэсгийн ахлагчийн хувьд Төсвийн байнгын хороогоор үүнийг хэлэлцье гэдэг саналыг гаргаад Төсвийн байнгын хороогоор хэлэлцээд үндсэндээ тэр 3 төрлийн хөнгөлөлт, хувь хүний орлогын албан татвар, тэр НӨАТ-тай холбоотой төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, материал худалдаж авах хуулиуд бүгдийг нь татуулчихсан юм.

Тэгэхээр энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувь гэхлээр чинь байна шүү дээ. Одоо үндсэндээ манайд чинь бол энэ яг органик гэж үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн маань нийт хүнсний бүтээгдэхүүний 0.5 хувийг л эзэлж байгаа юм л даа яг өнөөдрийн байдлаар. Үүнийг дэмжихийн тулд л нөгөө төрөөс энэ дэмжлэгийг яаж үзүүлдэг вэ гэхээр түрүүн ярьсан шүү дээ татварын бодлогоор дэмжлэг үзүүлнэ, урт хугацаатай, бага хүүтэй зээлээр юу яана, тэгээд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдаж авна гээд. Энэ хүрээнд л ингэсэн юм. Надад гаргаж өгсөн тооцооллоор бол Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан өнөөдөр 14 аж ахуйн нэгж л яг энэ органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна л даа. Тэгээд эд нарын тэр үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийх нь үнийн дүн нь их бага юм байна лээ. 31-50 орчим сая төгрөгийн л бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа юм байна лээ. Яг үүгээр ингээд л тооцохоор улсын төсөвт 90 хувийн хөнгөлөлт гээд үзэхээр зэрэг 63 сая төгрөгийн л тооцоо гарах юм байна лээ л дээ.

Тэгэхээр энэ заалтыг хасах юм бол энэ хууль бол үндсэндээ эдийн засгийн ямар нэгэн дэмжлэггүй л болж байна л даа. Үүнийг яах юм байгаа юм? Хууль санаачлагч нар нь яах юм байгаа юм. Үүнд өөр ямар ч байсан эдийн засагт дэмжлэг байхгүй. Ганцхан энэ аж ахуйн нэгжийн орлого. Энэ их органик бүтээгдэхүүн их хэмжээгээр үйлдвэрлээд их хэмжээний татварын тийм төсөвт ачаалал ирэх хүртэл бол бас нэлээн зай байх болов уу л гэж бодож байгаа. Тэр тутмаа бол тэр хар зах үүсгэхгүй байх талын юмыг бол төрийн зохицуулалтуудаар, бодлогоор, хяналтаар хийгээд явах боломж байгаа юм болов уу. Энэ 2025 оноос тэгэхдээ мөрдөгдөнө. Энэ органик бүтээгдэхүүнийг л дэмжье л гэсэн ганц санал энд явж байгаа юм л даа. Үүнийг ярьцгаах нь зүйтэй байх.

**Ж.Батжаргал:** Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл дээр бид дэмжих өөр маш олон боломжууд байгаа.ч Одоо гэсэн явж байгаа үнсний аюулгүй байдлын бодлогын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн яам сайдын багц дээр тавигдсан. Маш олон дэмжлэгүүд байгаа. Тэр хүрээндээ ороод явж болно. Үүн дээр органик бүтээгдэхүүн гэдгийг бид ер нь дэлхийн стандартыг нь интеграцид нийлж байгаа гэдгийгээ л бид дэлхийд зарлаж байгаа гэж би ингэж ойлгож байгаа. Тэртээ тэргүй энэ чинь өөрөө яг зорилтот зах зээл байдаг, зорилтот зах зээл. Би дахиад хэлье масс үйлдвэрлэлийг нь дэмжихгүй байж байж ийм бага хэмжээн дээр ийм дэмжлэг үзүүлнэ гэдэг чинь юу гэсэн үг вэ. Яг ард түмнээ бид нар дэмжиж байгаа тэр, одоо бол та нар ингэх нь байна шүү дээ. Гуравхан маш бага хувь нь органик бусад нь хортой шүү, органик биш шүү гэж зарлаж байгаа шүү дээ нэг талаар. Түүн дээрээ үүнийгээ дэмжихгүй, масс үйлдвэрлэлийг хангаад байгаа үүнийгээ дэмжихгүй, ингэж энэ дээр татвар дээр ялгаварлан гадуурхах ийм байдал байж.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Одоо ажлын хэсгийн 3 дугаар микрофон юм уу, хэд юм, 2 юм уу? 2 дугаар микрофон.

**Б.Алтанцэцэг:** Жавхлан сайдын асуултад гишүүний асуултад хариулъя. Ер нь яах вэ органик бүтээгдэхүүн түрүүн хэлсэн нийт үйлдвэрлэлийн, зөвхөн хүнс дээр ярьж байгаа бордоо гэх мэтчилнээр ингээд харахаар зэрэг 0.1 хувьдаа ч хүрэхгүй явж байгаа. Дэлхий нийт энэ рүү ерөөсөө яваад орчихсон. Яагаад масс үйлдвэрлэлээс ялгаад байна вэ гэхээр энэ өөрөө эргээд байгаль орчинд аягүй чухал нөлөөтэй. Хүний эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн ийм үйлдвэрлэл учраас бид нар ядахдаа аж ахуйн нэгжийнхээ хэрэв аж ахуйн нэгж үйлдвэрлэж байвал тэрийг нь татварын бодлогоор дэмжье гэсэн энэ саналыг оруулсан. Одоогийн байдлаар угаасаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23.2 дээр үр

тариа, төмс хүнсний ногоо, түүний үр жимс, жимсгэнэ, түүний үр суулгац, тэжээлийн ургамал, модны суулгац гээд 50 хувь хөнгөлөгдөөд явж байгаа аж ахуйн нэгжийн орлогын татвараас. Тэгэхээр зэрэг.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгчих дөө. Гүйцээгээд хариулаадаа даа.

**Б.Алтанцэцэг:** Тэгээд гадаад орнууд болохоороо зэрэг Европын Холбооны орнууд жишээлэх юм бол 2030 он гэхэд нийт үйлдвэрлэл хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийнхээ 25-30 хувийг органик шилжүүлж байгаа юм. Тэгэхээр зэрэг тэнд бол бас байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндийг дэмжсэн энэ ирээдүй хойч үедээ үлдээх гэсэн ийм байгальд ээлтэй үйлдвэрлэлийг үлдээх гэсэн ийм зорилго гээд өөрөө эргээд татварын гэхээсээ илүү өөр ач холбогдол нийгэм болон эдийн засагт ач холбогдол, нийгмийн эрүүл мэндэд ялангуяа ач холбогдол маш чухал. Бид нарын энд жишээ нь химийн гаралтай зохиомол аргаар нийлэгжүүлсэн бодис, бордоо гэх мэт орцуудыг оруулдаггүй байгаа.

Хоёрт хувиргасан амьд организмыг хэрэглэдэггүйгээрээ илүү ач холбогдолтой. Тэгэхээр зэрэг бид нар жоохон ч гэсэн энэ үйлдвэрлэлээ дэмжиж, ер нь бол цаашид түгээх зорилгыг л агуулсан.

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайд.

**Х.Болорчулуун:** Энэ том газар нутагтай, бага хүн амтай манай улсын хувьд органик бүтээгдэхүүн гэдэг нь маш чухал л даа. Ялангуяа тэр тусмаа хүнс дээр. Органик бүтээгдэхүүнийг улс орон дэмжихдээ татварын төрийн бодлогоор л хөнгөлөлт, чөлөөлөлтөө дэмждэг. Тэр ингэж хөнгөлж чөлөөлснөөрөө төсөвт дарамт учраад, олон тэрбумаар хөнгөлөгдөөд төсөвт дарамт учирна гэсэн асуудал байхгүй шүү. Тэгэхээр бид нар органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж

ахуйн нэгжүүддээ хөрөнгө мөнгийг май гээд өгөх ийм боломж байхгүй. Энэ татварын бодлогоор л дэмжих ёстой. Тэгэхээр Сангийн сайдын түрүүний хэлдэг татварын дарамт оччихно гэсэн асуудал байхгүй шүү л гэдгийг бас хэлмээр байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Баярлалаа. Жавхлан сайд ер нь дэгийнхээ дагуу хэлэлцэх асуудал руугаа орёе. Жавхлан сайдын микрофоныг өгчих.

**Б.Жавхлан:** Тийм, Болорчулуун сайд энэ асуудлуудыг Засгийн газар дээр дэмжээгүй шүү. Та сүүлийн үед хэд хэдэн асуудлууд дээр Засгийн газрын энэ бодлогууд дээрээ дандаа эсрэг байгаад байх юм. Энэ Засгийн газар дээр дэмжигдээгүй асуудал шүү дээ. Та түрүүн хэллээ тэр аль яамных юм 0.1 хувь гэж байна. Цаашидаа 20, 30 хувь болох гэж байгаа юм бол энэ төрлийн татварыг, орлогыг 20, 30 хувиар та нар танана гэсэн үг шүү дээ. Би танд үг хэлж байна хөөе. Би танд хандаж үг хэлж байна.

Тэгэхээр наадах чинь өнөөдөр хар аа татварын энэ бодлого, татварын хувь хэмжээ цаад хэмжээндээ биш, цаад хэмжээндээ биш, энэ хэмжээнээсээ үл хамаараад өөрөө энэ аягүй том дараагийн үл ойлголцох юм уу, дараагийн энэ болохгүй ийм жишгүүдээ тогтоож, үүнийгээ нээж байдаг. Би бүүр дахиад дахиад бүүр нэг заалт бүүр дахиад хэлье. Та нар ерөөсөө үг хэлж байгаа юмнууд яамных нь байхгүй. Хар аа нөхөн сэргээх дээр энэ юу гэж байгаа юм бэ? Нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад үйлдвэрлэсэн, баталгаажсан мэдээллийн санд бүртгэлтэй органик бордоог ашиглана гээд. Импортын органик бордоог нөхөн сэргээхдээ ашиглаж болохгүй юм уу? Энэ ямар компани бордоо хийгээд, үүнийгээ ингэж монопол болгож ингэж бүүр хуульчлах гээд байгаа юм?

Арайхийж нөхөн сэргээх гээд зах зээл дээр аль нь хямд боломжтой

органик бордоо байна тэрийгээ авчраад нөхөн сэргээлтээ хийг л дээ. Тэгж бүүр нөхөн сэргээлтээ хийе гэж байхад нь болохгүй ээ хуулиараа заавал та нар тэр компанийн шошготой дотоодод үйлдвэрлэсэн бүүр бордоог ав гэж ингэж хуульчилж ийм байдал үүсгэж болохгүй шүү дээ. Энэ ямар компанийн захиалгаар та нар ийм юм хийгээд байгаа юм? Энэ заалт болохгүй шүү.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр Ашигт малтмалын тухай хуулийн хууль дотор чинь хэлэлцэх явцдаа саяын асуудлыг ярья. Одоо сая Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэдүүлээ сонсчихсон. Тийм учраас төсөл өргөн баригчаас Хүн амын орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг татаж авч байгаагаа илэрхийлсэн.

Гэхдээ Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар дээр уншигдаж татагдаагүй байгаа тул бид дэгийнхээ дагуу уг хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн байх ёстой. Энэ үүднээсээ хэлэлцүүлгийг нь хийчихье. Тэгээд тэнд яригдаад татагдчихаар нь зэрэг энэ асуудал цаашиаага яг тэр татагдсан юугаараа явах ёстой юм гэж.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс санал бэлтгэгдээгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс санал бэлтгэгдээгүй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах

оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Одоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс 1 санал бэлтгэгдсэн байна.

Хуулийн Төслийн 1 дүгээр зүйлийн 22.5.10<sup>1</sup> дахь заалтын “6.1.1-д” гэснийг “4.1.2-т” гэж өөрчилж, мөн заалтын “буюу тариалсан” гэснийг хасах. Санал хураалт.

Байгаа юм. Тэр саналын томъёоллын харин өөрчилж юу яаж байгаа юм. Хөөе, Болороо гишүүн санал гаргаарай. Тийм ажлын хэсэг дээр ярьсан юм. Үйлдвэр гэдэг юутайгаа юу яахгүй байна гэсэн биз дээ энэ чинь? Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр юу гэлээ? Үгүй ээ үгүй та хэдийн саналын томъёолол чинь ингээж орж ирчхээд байна шүү дээ одоо. Найруулгын өөрчлөлт орж ирчхээд байна шүү дээ. Тийм. Тэрийгээ харин хэл л дээ энэ чинь. Би гэнэтхэн санал гаргаж ирээд хураалгачихсан юм шиг юм болох гэж байна шүү дээ энэ чинь. Хууль санаачлагчийн өргөн барьсан төсөл дотор таны хэлж байгаа тоо юмнууд байгаа юм. Ажлын хэсэг ажиллаад 1 дүгээр зүйл дээр нь зөвхөн саяын миний уншсан найруулгын өөрчлөлтийг л оруулж ирж байгаа. Санал гаргахгүй юм уу? Саяын санал хураалтаар саяын саналын томъёолол дэмжигдсэнгүй. Тийм учраас төслөөрөө үлдсэн гэсэн үг. Ингээж ойлгоорой.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд бий юу? Алга байна. Бэлтгэгдсэн санал байхгүй.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Эндээс бэлтгэгдсэн санал байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэгдсэн санал байхгүй.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй. Ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Болоогүй шүү. Одоо юу байгаа шүү.

Органик бүтээгдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Бэлтгэгдсэн санал байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Бэлтгэгдсэн санал байхгүй.

Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу?

Жавхлан сайд. Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

**Б.Жавхлан:** Хэн нь хариулах юм би сайн мэдэхгүй байна. Энэ санаачлагч хариулах юм уу, ажлын хэсгээс хариулах юм уу? Үүнийг тайлбарлаж өгөөч. Нөхөн сэргээх арга хэмжээг авна гэдэг чинь өөрөө бас их бид нар хүндэтгэлтэй хандах ажил шүү дээ. Тэрэнд хэрэглэх бордоогоо Монгол Улсад үйлдвэрлэсэн, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй органик бордоог ашиглана гээд. Ингээд монопол руу нь чиглүүлээд, нөгөө шошго гэдэгтэйгээ хамт энэ рүүгээ чиглүүлээд явуулчихаар нөхөн сэргээх хийх тийм боломжтой компаниуд энэ рүүгээ сонирхол нь ер нь яах юм? Аль болох өртөг багатайгаар шаардлагад нь нийцсэн нөхөн сэргээлт хийхийн тулд импортоор оруулж ирсэн тэрэндээ мэдээж баталгаажсан ийм импортын бордоо хэрэглэж болохгүй болж таарах уу? Импортын бордоог, дотоодод үйлдвэрлэсэн бордоог хэрэглэх нь чухал юм уу, нөхөн сэргээлтээ хийх нь чухал юм уу? Эсвэл тэр цөөхөн мэдээллийн санд бүртгэгдсэн Монгол Улсад заавал үйлдвэрлэсэн бордоог

хэрэглэж байх нь чухал юм уу? Үүнийгээ хариулж өгөөч.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсэг, Баттөмөр гишүүн. Баттөмөр гишүүний микрофоныг өгөөрэй.

**Б.Баттөмөр:** Бэлдэж ирж хариулаарай. Би зүгээр өөртөө яачихъя. Миний, надад байж байгаа мэдээллээр 11 аж ахуйн нэгж бүртгэлтэй гэж би ойлгож байна. Тэрнээс яг үйлдвэрлэж байгаа нь 8 гэж байгаа юм. Тэгэхээр энэ яах вэ эд оруулж ирэхдээ дотоодын үйлдвэрлэлээ дэмжье л гэсэн ийм санаагаар оруулж ирсэн байх. Үүн дээр одоо ажлын хэсэг тэгж ингэе гээгүй. Зүгээр сая тэр Жавхлан сайдын хэлж байгаа тэр импортыг хаагаад, дотооддоо гэж байгаа гэж байгаа бас аж ахуйн нэгжийн лобби явж байгаа маягтай ч юм бас ойлгогдоод байж байж магадгүй юм байгаа юм. Тэгэхээр зэрэг тэр органик бордоо хэрэглэнэ гэдгээ л тэр дотоодын гэдгээ л орхичихъя л доо. Болно биз дээ тийм ээ? Дотоодын гэдгээ хасчихъя. Найруулгыг нь тэр ажлын хэсэг дээр нь, айн? Яах вэ энэ хууль санаачлагч энэ тэрээс оруулж ирсэн ийм санаа байгаа юм. Үүнийг шууд.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайд.

**Х.Болорчулуун:** Их массаар тарьдаг том талбайтай, үр тариан дээр органик бордоо төдийлөн хэрэглэж чадахгүй байгаа л даа. Химийн бордоо хэрэглэж байгаа, гаднаас авч байгаа. Ялангуяа хүнсний ногоон дээр органик бордоо хэрэглэж байгаа энэ бол органик бордоон дотор бол бууцаар бордож байгаа энэ бууцны бордоо, мөн хонины ноосоор сүүлийн үед 2, 3 ч компани хонины ноосноос бордоо гаргаж хийж байгаа. Энэ болгоныгоо л дэмжих үүднээс л энэ зүйл, заалтууд орж ирж байна гэж ойлгож болно.

Ер нь органик бордоо төдийгүй органик бүтээгдэхүүн гаргахад өөрөө их зардал өндөртэй болохоор бас тодорхой

хэмжээний татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг улс орнууд олгож байсан л даа. Тэгж байж л органикийг дэмждэг. Түүнээс биш байгаа байдлаар нь органик нь өрсөлдөөд гараад ирнэ гэвэл бүүр бас хүндрэлтэй.

**Ж.Батжаргал:** Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Сүүлийн үед ер нь тэгэхдээ ийм тарифын хоригоор дамжуулж үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ, дэмжинэ гээд нэг ийм асуудлууд л их яригддаг боллоо. Нэн ялангуяа Хөдөө аж ахуйн яам маань оруулж ирж байгаа. Бас нэг бодлогын буруу биш л дээ. Харамсалтай нь энэ олон улс дэлхий дээр энэ тарифын хориг тавьж байгаад үндэснийхээ үйлдвэрлэлийг хөгжүүлсэн улс орон гэж бараг байдаггүй юм байна лээ. Энэ Европ 60, 70 онд яг ингэж нэн ялангуяа Герман улс дангаараа өөрийнхөө зөвхөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх оролдлогыг хийгээд тухайн үед хөдөө аж ахуйн салбар нь дампуурч байсан. Харилцан өөрсдийнхөө боломж дээр тулгуурласан бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд тэрийгээ бусдынхаа зах зээл дээр гаргаад, бусад улсынхаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг харилцан худалдаж аваад ингэж явах нь дэлхийн улс орнуудын хандлага байдаг.

Тэгэхээр бид ч гэсэн энэ замаар л явах ёстой байх л гэж би бодож байна. Яагаад бид нар заавал бүх юмыг өөрсдөө хийдэг болно гэдэг ийм утон ийм эдийн засгийн бодлоготой болчхож болохгүй л дээ. Бид нар чаддаг юмаа үйлдвэрлээд. Би жишээ хэлэхэд Дорнодын гурил манай сайдын үйлдвэрлэсэн гурил гэхэд Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтын конторвандын бүтээгдэхүүн байхгүй юу. Өвөр Монголын малчид түүнийг худалдаж авахын тулд манай Монголчууд тэрийг фургоноор зөөгөөд тэр зах зээл рүү гаргадаг. Хятадын тарифыг давж байгаа байхгүй юу. Энэ бид нар энэ бүтээгдэхүүнээ харин илүү их масс үйлдвэрлэл хийгээд яаж тэр зах зээл рүү нь оруулах вэ гэдэг тэр хэлцлүүдээ л бид нар хийх ёстой.

Ингэж чадах юм бол бид нар Монголын эрс тэс уур амьсгалтай хөрсөн дээр ургасан улаан буудайн онцлог амттай энэ шинэ сортын гурилыг бид нар яг тэр бууз иддэг хүмүүст нь хүргэж өгөх энэ бид нар энэ бодлогыг баримтаар байгаа байхгүй юу. Ингэж чадах юм бол бид нар уг нь явна. Тэрнээс бүх бүтээгдэхүүн дээрээ бид нар тариф, зөвхөн дотоодын хэрэгцээ рүүгээ хангасан үйлдвэрлэлийн бодлого хийчхээд яаж бид нар манай улс орон цаашаа хүнсний үйлдвэрлэлээ хөгжих юм бэ? Хүнсний ногоон дээр ч гэсэн адилхан. Өнөөдөр бодлогоор бид нар хүнсний ногоочдоо дэмжээд байна, 2 жилийн дараа бид нар хүнсний ногооны илүүдэлтэй болно. Энэ чинь өөрөө хувь юугаар өсөөд байна шүү дээ. Бид нар өнөөдөр импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ бид нар өнөөдөр дэмжиж бодлогоо барьж байгаад цаана нь бид нар эргээд экспортоо дэмжих бодлогоо давхар бодож байхгүй бол нэг талдаа бодоод байхаар бид нар бүгдээрээ яг энэ мах шигээ үнэ цэнгүй баахан бүтээгдэхүүнтэй болно.

Тэгэхээр бид нар экспортоо яаж дэмжих вэ гэдгээ байнгын бодож бодлогоо гаргаж байх ёстой. Ер нь бид нар бидний гол чадах, идэх л бүтээгдэхүүн байгаа шүү дээ хүнсний ногоо, мах, тэгээд гурил гэсэн. Үүн дээрээ хэдүүлээ дараагийнхаа том давлагаа, бодлогуудаа хийе л дээ. Өнөөдөр газар тариалангийнхаа тэр эрхэлж байгаа талбайн хэмжээг нэмэх ёстой бол тэрийгээ нэмье л дээ. Ногоон тэжээлээ массаар нь хэдүүлээ тарья л даа.

Тэгэхгүй бид өнөөдөр байгаа жижигхэн хүрэн дотроо бүх юмаа ингээд л барина гээд л ингээд ийм жижиг бодлого руу л ороод байгаа юм шиг л харагдаад байгаа байхгүй юу. Тэрний яг нэг жишээ энэ нөхөн сэргээлтийн асуудал дээр юу оруулж ирнэ гэдэг чинь бараг л тэнэглэл шүү дээ. Органик бордоо оруулж ирнэ гэдэг чинь. Бид нар өөрсдийнхөө хүнсний хэрэглээнийхээ



бордоог органик бус бордоо, химийн бордоо ашиглагчдад одоо тэнд заавал уул уурхайн их мөнгө олдог учраас тэд нарыг дампууруулна гэсэн ийм бодлого юм уу.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр органик бордоо үнэтэй ч гэж бас хэлчхээгүй л дээ яг хэдүүлээ бол. Үгүй ээ тийм юм байхгүй. Наадах чинь Монголчууд нүүдлийн мал аж ахуйгаа дагаад үндсэндээ бууц чинь өөрөө байгалийнхаа жамаар органик бордоо болоод л явж байгаа ийм л үйл явц шүү дээ. Тэрийг бид үйлдвэрлэлийн аргаар тодорхой температурт богино хугацаанд бэлтгэж байгаа бордоогоо бид түүгээрээ ойлгож байгаа.

Дээр нь сүүлийн үед энэ хонины ноосны буюу тэр зунгагтай бутархай ноосоор бордоо хийж байгаа. Тэр нь үндсэндээ хүнсний ногоо энэ тэр бордооно гэхээсээ илүүтэйгээр энэ мод, бут, сөөг бордох чиглэл рүүгээ илүү яваад байгаа юм байна лээ. Тэр тал руугаа илүү нийцэж байгаа гэсэн ийм л юм байгаад байгаа юм.

Одоо дэгийнхээ дагуу ажлын хэсгээс хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан 1 саналын томъёолол бэлтгэгдсэн байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 39.1.4.5 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.1.4.5.нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад үйлдвэрлэсэн, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй органик бордоог ашиглах;”. Санал хураалт.

25 хувийн саналаар энэ санал уналаа. Болоогүй шүү.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Бэлтгэгдсэн санал байхгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Ажлын хэсгээс бэлтгэгдсэн санал байхгүй.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Одоо юу билээ?

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн дагасан хууль Ерөнхий боловсролын сургуулийн.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд бий юу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэгдсэн санал байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэгдсэн санал байхгүй.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Ажлын хэсгээс 1 санал бэлтгэсэн байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь заалтын ““үйлдвэрлэл” гэсний дараа “импорт, экспорт” гэж тус тус” гэснийг хасах. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй.

хэсгийнхэнд баярлалаа. Байнгын хорооны өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө.

16.37 цаг

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Энэ хэн дараад байгаа юм бэ? Байхгүй, ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Бэлтгэсэн санал байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Эндээс бэлтгэсэн санал байхгүй.

Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энэ хуулийг хэлэлцэж дууслаа.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч танилцуулчих уу? Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн танилцуулна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хааж байна. Ажлын